



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2019 оны 10 дугаар сарын 07  
№38/1091/

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын  
хууль**

**Ноот бичиг соёрхон  
батлах тухай**

**Монгол Улсын  
Засгийн газрын  
тогтоол**

**Үндэсний хөтөлбөр  
батлах тухай**

**Монгол Улсын  
олон улсын  
гэрээ**

**Монгол Улсын Засгийн газар  
Бүгд Найрамдах Беларусь  
Улсын Засгийн газар хоорондын  
экспортын зээлийн ерөнхий  
хэлэлцээр**

**ГАРЧИГ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

- |      |  |      |
|------|--|------|
| 312. | Ноот бичиг соёрхон батлах тухай                          | 1398 |
| 313. | Экспортын зээлийн ерөнхий хэлэлцээр соёрхон батлах тухай | 1398 |
| 314. | Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр соёрхон батлах тухай     | 1399 |

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

- |      |                                |            |      |
|------|--------------------------------|------------|------|
| 315. | Үндэсний хөтөлбөр батлах тухай | Дугаар 202 | 1399 |
|------|--------------------------------|------------|------|

**МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ**

- |      |   |      |
|------|---|------|
| 316. | “БНМАУ-д тусламж үзүүлж буй зөвлөлтийн мэргэжилтнүүдийг байраар хангах, үйлчлэх зорилгоор БНМАУ-д орон сууц болон хэрэгцээт соёл, ахуйн объектуудыг барих тухай БНМАУ-ын Засгийн газар, ЗСБНХУ-ын Засгийн газар хоорондын 1971 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн протокол” болон “ЗСБНХУ-аас БНМАУ-д нийлүүлж буй машин, тоног төхөөрөмж болон бусад эд ангийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэхэд зориулан зөвлөлтийн техникийн төвүүдийг байгуулахад зориулж БНМАУ-ын нутаг дэвсгэрт газар олгох, барилга барих нөхцөлийн тухай БНМАУ-ын Засгийн газар, ЗСБНХУ-ын Засгийн газар хоорондын 1979 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн хэлэлцээр”-т нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын ноот бичиг | 1411 |
| 317. | Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хоорондын экспортын зээлийн ерөнхий хэлэлцээр  | 1424 |
| 318. | Монгол Улсын Засгийн газар, Европын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр  | 1428 |



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 09 дүгээр  
сарын 12-ны өдөр

Улаанбаатар  
хот

### НООТ БИЧИГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**“БНМАУ-д тусламж үзүүлж буй зөвлөлтийн мэргэжилтнүүдийг байраар хангах, үйлчлэх зорилгоор БНМАУ-д орон сууц болон хэрэгцээт соёл, ахуйн объектуудыг барих тухай БНМАУ-ын Засгийн газар, ЗСБНХУ-ын Засгийн газар хоорондын 1971 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн протокол” болон “ЗСБНХУ-аас БНМАУ-д нийлүүлж буй машин, тоног төхөөрөмж болон бусад эд ангийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэхэд зориулан зөвлөлтийн техникийн төвүүдийг байгуулахад зориулж БНМАУ-ын нутаг дэвсгэрт газар олгох, барилга барих нөхцөлийн тухай БНМАУ-ын Засгийн газар, ЗСБНХУ-ын Засгийн газар хоорондын 1979 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн хэлэлцээр”-т нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын ноот бичгийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 09 дүгээр  
сарын 12-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЭКСПОРТЫН ЗЭЭЛИЙН ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хооронд 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр байгуулсан “Экспортын зээлийн ерөнхий хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 09 дүгээр  
сарын 12-ны өдөр

Улаанбаатар  
хот

### САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын Засгийн газар, Европын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд 2019 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр байгуулсан “Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 5 дугаар  
сарын 22-ны өдөр

Дугаар 202

Улаанбаатар  
хот

### Үндэсний хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.31, 2.77, 5.1.12 дахь зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.3, 10.5, Орон сууцны тухай хуулийн 6.1.1, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 25.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. “150 мянган айл-Орон сууц” үндэсний хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2019 оны 2 дугаар улиралд багтаан баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделханд даалгасугай.

3. Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах, түүнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжид хамруулах



болон төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**У.ХҮРЭЛСҮХ**

**БАРИЛГА, ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН САЙД**

**Х.БАДЕЛХАН**

Засгийн газрын 2019 оны 202 дугаар  
тогтоолын хавсралт

**“150 МЯНГАН АЙЛ-ОРОН СУУЦ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР**

Нэг. Ерөнхий мэдээлэл

Манай улсад 2018 оны байдлаар нийт 894,496 өрх байгаагийн 387,453 өрх нь нийслэлд, 507,043 өрх нь орон нутагт амьдарч байна.

Нийслэлийн 174,491 өрх нийтийн зориулалттай орон сууцанд, 3664 өрх нь амины орон сууцанд, 107,878 өрх нь гэр хорооллын байшинд, 101,136 өрх нь гэрт амьдарч, 284 өрх нь өөрийн гэсэн орон гэргүй байна.

Орон нутгийн 194,307 өрх аймгуудын төвд амьдарч байна. Аймгуудын төвд амьдарч байгаа эдгээр өрхийн 58,838 өрх нь нийтийн болон амины орон сууцанд, 135,469 өрх нь гэр, гэр хорооллын байшинд амьдарч байна.

Ирэх 5 жилд нийслэлийн 216,913 өрх, орон нутгийн 121,929 өрх орон сууц худалдан авах хүсэлтэй байгаа бөгөөд тэдгээрээс нийслэлийн 16,3 хувь буюу 35,497 өрх, аймгуудын 9,6 хувь буюу 11,738 өрх нь орон сууц худалдан авах чадвар нь баталгаажсан эрэлттэй байна.

Нийслэлийн 73,336 өрх, орон нутгийн 37,266 өрх өөрийн өмчлөлийн газартаа инженерийн хангамж бүхий амины орон сууц барих, нийслэлд 44,747 өрх, орон нутагт 32,048 өрх орон сууц түрээслэн амьдрах хэрэгцээтэй байна.

Улсын хэмжээнд нийт 192,475 төрийн албан хаагч ажиллаж байгаагийн 127,585 нь өөрийн өмчлөлийн орон сууцтай байгаа бөгөөд тэдгээрийн 62,666 нь боловсролын салбарт, 20,401 нь эрүүл мэндийн салбарт ажиллагсад байна. Орон сууц худалдан авах хэрэгцээтэй 56,467 төрийн албан хаагч байгаагийн 15,360 нь худалдан авах чадвар нь

баталгаажсан эрэлттэй байна.

Сүүлийн жилүүдэд орон сууцны барилгууд олноор баригдаж, ашиглалтад орж байгаа хэдий ч бага, дунд орлоготой иргэдийн худалдан авах чадварт нийцсэн орон сууцны нийлүүлэлт хомс байна.

Сүүлийн жилүүдэд хот, хөдөөгийн хөгжлийн хэт ялгаа, ажилгүйдэл, ядуурал зэрэг нийгмийн сөрөг хүчин зүйлийн нөлөөгөөр эмнэлэг, боловсрол, соёлын болон бусад нийгмийн үйлчилгээнд ойртох, зах зээлийн эрэлтийг даган ажлын байртай болох зорилгоор иргэд хот, суурин газарт олноор шилжин суурьших болсноор төлөвлөлт, зохицуулалтгүй гэр хороолол ихээхэн нэмэгдэж байна.

Ийнхүү өсөн нэмэгдэж байгаа хотжилт, дэд бүтцийн хүртээмжгүй байдал нь хот, суурин газрын хөрс, ус, агаарын бохирдлыг үлэмж нэмэгдүүлж, иргэдийн эрүүл мэндэд ноцтой аюул учруулж байна.

Дээр дурдсан хэрэгцээ, шаардлагыг харгалзан, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “2.31.Малчдыг орон сууцны хөтөлбөрт хамруулах, нийгмийн асуудлыг шийдэх арга хэмжээ авна.” гэж, “2.77. Хүн амын орон сууцны хэрэгцээг хангах зорилгоор нэгдсэн бодлого боловсруулж, “Хямд өртөгтэй орон сууц” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.” гэж, “5.1.12. Төрийн албан хаагчийн орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлж, нөхцөлийг сайжруулах бодлого баримтална.” гэж тус тус заасан зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор Улсын Их Хурлын 1999 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрөөс орон сууцны талаар баримтлах бодлого” болон иргэдийг орон сууцжуулах чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдтэй уялдуулан энэ хөтөлбөрийг боловсрууллаа.

#### Хоёр. Хөтөлбөрийн зорилго

2.1. Хөтөлбөрийн зорилго нь төв, суурин газарт амьдардаг нийт ерхийн дийлэнх олонхын худалдан авах чадварт нийцсэн, Монгол орны цаг уурын нөхцөлд тохирсон, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан, инженерийн бүрэн хангамжтай орон сууцтай болох нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

#### Гурав. Хөтөлбөрийн зорилт

3.1. Хөтөлбөрийн зорилгыг дараахь зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ:

3.1.1. Орон сууцны санхүүжилтийн тогтолцоо, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

3.1.2. Хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу гэр хорооллыг иргэдийн оролцоотой дахин төлөвлөх замаар байгаль орчинд ээлтэй, ашиглалтын зардал багатай инженерийн дэд бүтцэд холбогдсон тохилог гэр, амины



болон нийтийн орон сууцны хороолол болгон хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх;

3.1.3. Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал багатай, ногоон хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг дэмжих;

3.1.4. Төрийн халамж, дэмжлэг зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн иргэдийн орон сууцны хангамж, нөхцөлийг сайжруулах.

#### Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1. Орон сууцны санхүүжилтийн тогтолцоо, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.1. иргэдийн орон сууцны хангамж, нөхцөлийг сайжруулахад чиглэсэн санхүүжилтийн тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлэх;

4.1.2. орон сууцны даатгалын тогтолцоог боловсронгуй болгох;

4.1.3. орон сууцны ашиглалт, үйлчилгээ хариуцсан байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг оновчтой тогтоох, нийтийн зориулалттай орон сууцны барилгын засвар, үйлчилгээний зардлыг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах;

4.1.4. гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлүүлэх;

4.1.5. орон сууцны хөнгөлөлттэй зээлийн урьдчилгаа төлбөрийг тэтгэврийн даатгалын нэрийн дансны хуримтлалаас бүрдүүлэх боломжийг судалж хэрэгжүүлэх.

4.2. Хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу гэр хорооллыг иргэдийн оролцоотой дахин төлөвлөх замаар байгаль орчинд ээлтэй, ашиглалтын зардал багатай инженерийн дэд бүтцэд холбогдсон тохилог гэр, амины болон нийтийн орон сууцны хороолол болгон хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.2.1. төв, суурин газрын гэр хорооллын газрыг иргэдийн шууд оролцоотойгоор дахин төлөвлөж, газрыг зүй зохистой ашиглах хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

4.2.2. инженерийн хангамжийн шугам сүлжээ, барилга байгууламжийг шинээр барих, шинэчлэх, өргөтгөх төслийг үе шаттай



хэрэгжүүлж, орон сууцны хотхон хороолол, түүний нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжийг барих нөхцөлийг бүрдүүлэх;

4.2.3. ухаалаг, бие даасан, дэвшилтэт технологи бүхий дэд бүтцийг улс, орон нутгийн төсвийн хөрөнгө, гадаад, дотоодын зээл, тусламж, концессын гэрээгээр барьж байгуулахыг дэмжих, байгалийн нөөцийн хэмнэлттэй, дэвшилтэт техник технологи, тоног төхөөрөмж нэвтрүүлэх, нутагшуулах;

4.2.4. гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах, дахин төлөвлөн барилгажуулах төслийг хэрэгжүүлэхэд барилга угсралтын болон барилгын материал үйлдвэрлэгч үндэсний компаниудыг татан оролцуулах;

4.2.5. иргэдийг гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах, төлөвлөхтэй холбогдсон мэдээ мэдээллээр хангах, сургалт, уулзалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх зэргээр иргэдийн идэвх санаачилгыг өрнүүлэх, иргэдийн бүлэг байгуулахад дэмжлэг үзүүлэх;

4.2.6. шинээр төлөвлөх орон сууцны хорооллын үнд ахуйн хэрэглээний цэвэр усыг тусад нь төлөвлөх, бохир усыг дахин боловсруулж, ариутгах татуургын системд технологийн зориулалтаар болон ногоон байгууламжийн усалгаанд ашиглах зэрэг техникийн шийдлийг зураг төсөлд тусгаж, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэх;

4.2.7. усны менежментийг боловсронгуй болгох, үнднаас бусад хэрэгцээнд гадаргын болон хуримтлуулсан ус, цэвэршүүлсэн процессын усыг хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх.

4.3. Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал багатай, ногоон хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг дэмжих зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.3.1. хот, суурин газрын хэт төвлөрлийг сааруулах, суурьшлын оновчтой тогтолцоог бүрдүүлэх хүрээнд дагуул, хаяа хот, дүүрэг, тосгодыг жигд тэнцвэртэйгээр хөгжүүлж иргэдийн орон сууцны хангамж, хүртээмжийг сайжруулах бодлогыг хэрэгжүүлэх;

4.3.2. орон сууцны барилгын эрчим хүч (цахилгаан болон дулаан)-ний хэрэглээний түвшинг тодорхойлж, гэрчилгээ олгох, дулааны эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээг тарифын бодлогоор дэмжих, тоолууржуулах замаар хэрэглээндээ тохирсон төлбөр төлдөг тогтолцоонд шилжих;

4.3.3. орон сууцны барилгыг байгалийн нөөцийн хэмнэлттэй байдлаар төлөвлөх, угсармал хийц, эдлэлээр барьж байгуулахтай холбогдсон норм, дүрэм, стандартыг боловсронгуй





болгох, мөрдүүлэх, энэ чиглэлээр инженер, техникийн ажилчдыг сургах, мэргэшүүлэх;

4.3.4. ногоон хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн дэд бүтцийг бий болгох, инженерийн хангамжид эрчим хүч, ус хангамжийн хэмнэлттэй, дэвшилтэт техник технологи, тоног төхөөрөмж, хэрэгслийг нэвтрүүлэх ажлыг бүх талаар дэмжих;

4.3.5. орон нутгийн засаг захиргаа, сууц өмчлөгчдийн оролцоотойгоор дулааны алдагдал ихтэй, угсармал орон сууцны барилгуудыг дулаалах, ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгуудыг буулгаж, шинээр барих төслүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлэх;

4.3.6. эрчим хүчний хэмнэлттэй, ногоон орон сууцны нийлүүлэлтийг дэмжих санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох;

4.3.7. ахуйн хог, хаягдлын менежментийн шинэ тогтолцоог бий болгох;

4.3.8. орон сууцны хотхон, хорооллын төлөвлөлтөд ногоон байгууламж, усан сан, биеийн тамирын талбай, хүртээмжтэй ил, далд авто зогсоол, оршин суугчид амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх тохилог орчинг бүрдүүлэх шаардлагыг тусган хэрэгжүүлэх;

4.3.9. хот, суурин газруудад шинээр баригдах орон сууцны хорооллын инженерийн хангамжийн шугам сүлжээг хонгилын системээр төлөвлөх, барих төслийг үе шаттай хэрэгжүүлэх.

4.4. Төрийн халамж, дэмжлэг зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн иргэдийн орон сууцны хангамж, нөхцөлийг сайжруулах зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.4.1. орон сууцны зориулалттай гадаад, дотоодын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн 30-аас доошгүй хувийг зорилтот бүлгийн иргэдийн орон сууцны хангамж, нөхцөлийг сайжруулахад зориулах;

4.4.2. хүн амын амьжиргааны түвшингээс доогуур орлоготой, 0-18 насны 4-өөс дээш хүүхэдтэй гэр бүл, өрх толгойлсон эцэг (эх), хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнуудыг тэргүүн ээлжинд халамжийн болон түрээсийн орон сууцаар хангах бодлогыг хэрэгжүүлэх;

4.4.3. төрийн албан хаагч орон сууц худалдан авах, орон сууцны нөхцөлөө сайжруулахад нь төрөөс дэмжлэг үзүүлэх хүрээнд дараахь арга хэмжээг судалж, боломжит хувилбараар хэрэгжүүлэх:

4.4.3.1. орон сууцны урт хугацаатай, бага хүүтэй зээлд хамруулах, зээлийн хүүг тодорхой хувиар бууруулах;



4.4.3.2. орон сууцны зээлийн эргэн төлөлтөд баталгаа гаргах;

4.4.3.3. төрийн албан хаагч орон сууцны зээлийн урьдчилгаа төлбөрөө төлөхөд нь зориулж, 3 хүртэл жилийн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламжийг тухайн ажиллаж байгаа байгууллагаас нь олгодог байх нөхцөлийг бүрдүүлэх;

4.4.3.4. гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн санхүүжилтэд төсвийн бус эх үүсвэрийг бий болгох замаар дэмжлэг үзүүлж, хэрэгжилтийг эрчимжүүлэн, бага хүүтэй, урт хугацаатай зээлийн нөхцөлөөр зорилтот бүлгийн иргэдийг орон сууцжуулах ажлыг төрөөс хариуцан зохион байгуулах;

4.4.3.5. төрийн албан хаагчдыг орон сууцжуулах зорилгоор орон сууц худалдан авах, захиалан бариулах;

4.4.3.6. улс, орон нутгийн төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр түрээсийн орон сууц захиалан бариулах;

4.4.3.7. төрийн албан хаагчдын орон сууц барих зориулалтаар төрийн байгууллагад газрыг холбогдох хууль, журмын дагуу давуу эрхээр олгохыг дэмжих;

4.4.3.8. төрийн байгууллага дотоод нөөц бололцоогоо ашиглан ажиллагсаддаа зориулан орон сууц бариулахыг дэмжих;

4.4.3.9. улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар төрийн албан хаагчдын орон сууцны инженерийн хангамжийн шугам сүлжээ, барилга байгууламж барих асуудлыг дэмжих;

4.4.3.10. төрийн албан хаагчдын цалинг эдийн засгийн өсөлт, инфляцийн түвшин, амьжиргааны өртөгтэй уялдуулан орон сууцны урт хугацаатай зээл авахад хүрэлцэхүйц хэмжээгээр нэмэгдүүлэх;

4.4.3.11. аймгийн төвөөс алслагдсан сумдад ажиллаж, амьдарч байгаа эрүүл мэнд, боловсрол, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагын албан хаагчдын ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд албаны орон сууцаар бүрэн хангах.

4.4.4. малчдын орон нутагтаа тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, тэдний нүүдэлчин ахуй нөхцөлд тохирсон, байгаль орчинд ээлтэй, ус, дулаан, эрчим хүчний хэмнэлттэй орон сууцтай болоход нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд авч хэрэгжүүлэх;



4.4.5. өрхийн амьжиргааг дэмжих, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бусад хөтөлбөр, төслийг хүн амын амьжиргааны доод түвшинээс доогуур орлоготой, ядуу иргэдийг орон сууцаар хангах, тэдний орон сууцны нөхцөлийг сайжруулах арга хэмжээтэй уялдуулан хэрэгжүүлэх.

Тав.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат, хугацаа

5.1. Хөтөлбөрийг 5 жилийн хугацаанд дараахь үе шаттай хэрэгжүүлнэ:

5.1.1. I үе шат: 2019-2020 он;

5.1.2. II үе шат: 2021-2023 он.

Зургаа. Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүн гарна:

6.1.1. төв, суурин газарт амьдардаг нийт өрхийн дийлэнх олонх нь инженерийн бүрэн хангамжтай орон сууцтай болж, ус, агаар, хөрсний бохирдол буурсан байна;

6.1.2. зорилтот бүлгийн иргэдийн орон сууцны нөхцөл сайжирч, тэдний тогтвор суурьшилтай ажиллах, амьдрах боломж нэмэгдэнэ;

6.1.3. ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгуудыг буулган шинээр барьснаар иргэд аюулгүй, чанартай орон сууцаар хангагдаж, хотын өнгө үзэмж сайжирна;

6.1.4. угсармал орон сууцны барилгуудыг дулаалж шинэчилснээр иргэдийн ая тухтай амьдрах нөхцөл бүрдэж, “Ногоон хөгжлийн бодлого”-ын зорилт хэрэгжихэд түлхэц болно.

6.1.5. иргэдийн амьдрах орчин сайжирснаар ажлын бүтээмж, амьжиргааны түвшин дээшлэх боломж нэмэгдэж, эрүүл мэндийн улмаас учрах эдийн засгийн хохирол буурна;

6.1.6. иргэдийг орон сууцжуулах үйл ажиллагаанд ногоон үйлдвэрлэл, технологийг нэвтрүүлснээр эрчим хүчний нөөц хэмнэгдэж, үүнтэй уялдан иргэдийн инженерийн хангамж, үйлчилгээтэй холбогдсон зардал буурна;

6.1.7. иргэдийг орон сууцжуулах ажлыг эрчимжүүлж, байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал багатай, үр ашигтай, хэмнэлттэй, ногоон хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн үйлдвэрлэлийг бий болгосноор ажлын байр нэмэгдэнэ.

Долоо. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

7.1. Хөтөлбөрийн үр дүнг 2018 оны үзүүлэлтийг суурь үзүүлэлт болгон ашиглаж, дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

Зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хариуцах байгууллага
			2018 он	2023 он	
Орон сууцны санхүүжилтийн тогтолцоо, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Инженерийн бүрэн хангамжтай орон сууцтай болох өрх	Хувь	38,1	66,6	Барилга, хот байгуулалтын яам
	Иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, нөхцөлийг сайжруулахад чиглэсэн хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх	Шинэчлэн боловсруулсан хууль	-	3	Барилга, хот байгуулалтын яам
		Шинээр болон шинэчлэн боловсруулсан барилгын норм ба дүрэм (БНБД)	220	225	Холбогдох төрийн захиргааны төв байгууллагууд
		Шинээр боловсруулсан журам, аргачлал	23	30	
		Шинээр боловсруулсан стандарт	640	646	



Хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу гэр хорооллыг иргэдийн	Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд шинээр баригдах орон сууц	айлын тоо	5,189	50,189	Барилга, хот байгуулалтын яам,  Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар
оролцоотой дахин төлөвлөх замаар байгаль орчинд ээлтэй, ашиглалтын зардал багатай инженерийн дэд бүтцэд холбогдсон тохилог гэр, амины болон нийтийн орон сууцны хороолол болгон хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх	Инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээний суурилагдсан хүчин чадлын ашиглалтыг сайжруулах, гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийн хүрээнд инженерийн хангамжид холбогдох амины орон сууц	айлын тоо	-	10,000	Барилга, хот байгуулалтын яам,  Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар



Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал багатай, ногоон хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг дэмжих	Шинэ суурьшил, дагуул, хаяа хот, тосгодыг хөгжүүлэх хүрээнд шинээр ашиглалтад орох орон сууц	айлын тоо	4,222	20,734	Барилга, хот байгуулалтын яам,  Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар
	Иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшлийн газар дээр шинээр баригдах орон сууц	айлын тоо	298,461	355,461	Төр, хувийн хэвшлийн түншлэл
	Барилгын материал, ус, эрчим хүчний хэрэглээний гэрчилгээ, шошго авах орон сууцны барилга	Барилгын тоо	-	20	Эрчим хүчний яам,  Барилга, хот байгуулалтын яам
	Орон сууцны барилгыг байгалийн нөөцийн хэмнэлттэй төлөвлөх, барих чиглэлээр мэргэшсэн инженер, техникийн ажилтан	тоо	-	200	Эрчим хүчний яам,  Барилга, хот байгуулалтын яам,  Байгаль, орчин, аялал жуулчлалын яам
	Нийтийн зориулалттай угсармал орон сууцны барилгыг дулаалах төсөлд хамрагдах орон сууц	блок барилга/ айлын тоо	5/300	88/7,300	Барилга, хот байгуулалтын яам,  Нийслэлийн Засаг даргын Тамгын газар



	Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгуудыг буулгаж барилгажуулах төслийн хүрээнд шинээр ашиглалтад орох орон сууц	айлын тоо	301	3,301	Барилга, хот байгуулалтын яам,  Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
	“Ногоон хувийн сууц” загвар төслийн хүрээнд ашиглалтад орох орон сууц	айлын тоо	-	80	Барилга, хот байгуулалтын яам,  Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
Төрийн халамж, дэмжлэг зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн иргэдийн орон сууцны хангамж, нөхцөлийг сайжруулах	Түрээсийн орон сууцанд хамрагдах зорилтот бүлгийн иргэн	тоо	-	18,488	Сангийн яам
	Шинээр орон сууцтай болох төрийн албан хаагч	тоо	127,585	157,585	Төрийн захиргааны төв байгууллагууд
	Шинээр орон сууцтай болох хөгжлийн бэрхшээлтэй иргэн	тоо	151	5,000	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Сангийн яам

**Найм. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр**

8.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

- 8.1.1. улс, орон нутгийн төсөв;
- 8.1.2. гадаадын зээл, тусламж;
- 8.1.3. гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;
- 8.1.4. Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас;
- 8.1.5. концесс;
- 8.1.6. бусад эх үүсвэр.

Ес. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ

9.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагууд дараа оны 1



дүгээр сард багтаан орон сууцны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

9.2. Орон сууцны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай бол хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулна.

9.3. Орон сууцны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулна.

9.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтэд үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

## МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

**“БНМАУ-д тусламж үзүүлж буй зөвлөлтийн мэргэжилтнүүдийг байраар хангах, үйлчлэх зорилгоор БНМАУ-д орон сууц болон хэрэгцээт соёл, ахуйн объектуудыг барих тухай БНМАУ-ын Засгийн газар, ЗСБНХУ-ын Засгийн газар хоорондын 1971 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн протокол” болон “ЗСБНХУ-аас БНМАУ-д нийлүүлж буй машин, тоног төхөөрөмж болон бусад эд ангийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэхэд зориулан зөвлөлтийн техникийн төвүүдийг байгуулахад зориулж БНМАУ-ын нутаг дэвсгэрт газар олгох, барилга барих нөхцөлийн тухай БНМАУ-ын Засгийн газар, ЗСБНХУ-ын Засгийн газар хоорондын 1979 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн хэлэлцээр”-т нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын ноот бичиг**

### ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

A/19-1206

Монгол Улсын Гадаад харилцааны яам Оросын Холбооны Улсын Гадаад хэргийн яаманд хүндэтгэлээ илэрхийлэхийн ялдамд 2019 оны 1 дүгээр сарын 22-ний өдрийн 538н/1да ноот бичгээр илэрхийлсэн оросын талын дараах агуулга бүхий саналыг Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс хүлээн зөвшөөрч буйг мэдэгдэх завшаан тохиов. Үүнд:

«Оросын Холбооны Улсын Гадаад хэргийн яам Монгол Улсын Гадаад харилцааны яаманд хүндэтгэлээ илэрхийлэхийн ялдамд Оросын Холбооны Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс БНМАУ-д тусламж үзүүлж





буй зөвлөлтийн мэргэжилтнүүдийг байраар хангах, үйлчлэх зорилгоор БНМАУ-д орон сууц болон хэрэгцээт соёл, ахуйн объектуудыг барих тухай БНМАУ-ын Засгийн газар, ЗСБНХУ-ын Засгийн газар хоорондын 1971 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн протокол (цаашид “протокол”) болон ЗСБНХУ-аас БНМАУ-д нийлүүлж буй машин, тоног төхөөрөмж болон бусад эд ангийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэхэд зориулан зөвлөлтийн техникийн төвүүдийг байгуулахад зориулж БНМАУ-ын нутаг дэвсгэрт газар олгох, барилга барих нөхцөлийн тухай ЗСБНХУ-ын Засгийн газар, БНМАУ-ын Засгийн газар хоорондын 1979 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн хэлэлцээр (цаашид “хэлэлцээр”)-т дараах нэмэлт, өөрчлөлт оруулахыг санал болгох завшаан тохиов:

1) Протоколд:

1 дүгээр зүйлд дараах агуулга бүхий догол мөр нэмэх:

“Оросын тал ОХУ-ын өмч болох үл хөдлөх хөрөнгийн объектууд болон өөрийн эрх ашиг, үүний дотор улсын хэрэгцээ, дипломат эрх ашгийг хангах үүднээс Зөвлөлтийн талд олгосон Улаанбаатар, Дархан хот (Дархан-Уул аймаг) дахь холбогдох эдэлбэр газрын хувьд хэлэлцэн тохиролцогч Талуудын хууль тогтоомж болон олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн өмчлөх эрх болон ашиглах эрхээ тус тус хэрэгжүүлнэ.”;

2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг дараах байдлаар найруулах:

“1. Монголын тал Улаанбаатар болон Дархан хот (Дархан-Уул аймаг) дахь эдэлбэр газар, тэдгээрт байрлаж буй ОХУ-ын өмчийн үл хөдлөх хөрөнгийн объектоо холбоотой эрхийг Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын нэр дээрх бүртгэлээс Оросын Холбооны Улсын нэр дээр шинэчлэн бүртгэнэ. Монголын тал эдгээр газрыг оросын талд холбогдох ашиглалтын гэрээнд заасан нөхцөлийн дагуу 60 жилээр ашиглуулах, ингэхдээ цаашид ашиглалтын хугацааг 40 жилээр аливаа нөхцөлгүйгээр сунгах эрхтэйгээр шилжүүлж өгнө.

Холбогдох эдэлбэр газрыг цаашид ашиглах нөхцөлийг Талууд 100 жилийн хугацаа дуусахаас хоёр жилийн өмнө хэлэлцээ хийх замаар хэлэлцэн тохиролцоно.

Хавсралт 1-ийн дагуу Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын нэр дээрх бүртгэлээс Оросын Холбооны Улсын нэр дээр шинэчлэн бүртгэвэл зохих Монгол Улсын нутаг дэвсгэрт орших эдэлбэр газар болон тэдгээрт байрлах оросын үл хөдлөх хөрөнгийн объектуудын жагсаалт нь энэхүү протоколын салшгүй хэсэг болно.

Дээр дурдсан эдэлбэр газарт тэдгээрийн ашиглалтын зориулалтыг харгалзан Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн дагуу монголын хуулийн этгээдэд ногдуулдаг болон олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу ногдуулдаг татвар, хураамжийг ногдуулна.”;

Дараах агуулга бүхий Хавсралт 1 нэмэх:

БНМАУ-д тусламж үзүүлж буй зөвлөлтийн мэргэжилтнүүдийг байраар хангах, үйлчлэх зорилгоор БНМАУ-д орон сууц болон хэрэгцээт соёл, ахуйн объектуудыг барих тухай ЗСБНХУ-ын Засгийн газар, БНМАУ-ын Засгийн газар хоорондын 1971 оны 7 дугаар сарын 29-ний едрийн протоколын Хавсралт 1.

**ЗСБНХУ-ын нэрнээс ОХУ-ын нэр дээр шинэчлэн бүртгэвэл зохих Монгол Улсын нутаг дэвсгэрт орших эдэлбэр газар болон тэдгээрт байрлах Оросын үл хөдлөх хөрөнгийн объектуудын жагсаалт**

д/д	Хамрах газрын хэмжээ (га)	Үл хөдлөх хөрөнгө	Нийт/ашигтай талбай кв.м	Давхар	Хаяг	
1	0.0775	Орон сууцны барилга №1	3300.80/ 3025.00	5	Улаанбаатар	Баянзүрх дүүрэг, 5-р хороо, 15-р хороолол (13343), Энх тайвны өргөн чөлөө
		Орон сууцны барилга №7	3300.80/ 3025.00	5	Улаанбаатар	Баянзүрх дүүрэг, 5-р хороо, 15-р хороолол (13343), Лхагвасүрэнгийн гудамж
4	0.8088	Орон сууцны барилга №8	3300.80/ 3025.00	5	Улаанбаатар	Баянзүрх дүүрэг, 5-р хороо, 15-р хороолол (13343), Лхагвасүрэнгийн гудамж
		Орон сууцны барилга №9	3300.80/ 3025.00	5	Улаанбаатар	Баянзүрх дүүрэг, 5-р хороо, 15-р хороолол (13343), Лхагвасүрэнгийн гудамж
		Орон сууцны барилга №10	3300.80/ 3190.00	5	Улаанбаатар	Баянзүрх дүүрэг, 5-р хороо, 15-р хороолол (13343), Лхагвасүрэнгийн гудамж



5	0.1305	Орон сууцны барилга №11	5381.50/ 4966.30	5	Улаанбаатар	Баянзүрх дүүрэг, 4-р хороо, 15-р хороолол (13344), Лхагвасүрэнгийн гудамж
6	0.1244	Орон сууцны барилга №12	5381.50/ 4966.30	5	Улаанбаатар	Баянзүрх дүүрэг, 4-р хороо, 15-р хороолол (13344), Лхагвасүрэнгийн гудамж
7	0.0760	Орон сууцны барилга №13	3300.80/ 3025.80	5	Улаанбаатар	Баянзүрх дүүрэг, 4-р хороо, 15-р хороолол (13344), Лхагвасүрэнгийн гудамж
8	0.5799	Орон сууцны барилга №14	6833.00/ 6292.18	5	Улаанбаатар	Баянзүрх дүүрэг, 4-р хороо, 15-р хороолол (13344), Хилчдийн гудамж
9	0.7413	Дотуур байр № 18а	866.52	2	Улаанбаатар	Баянзүрх дүүрэг, 4-р хороо, 15-р хороолол (13344), Лхагвасүрэнгийн гудамж, №12/3 дугаар барилга
		Дотуур байр № 18б	866.52	2		Баянзүрх дүүрэг, 4-р хороо, 15-р хороолол (13344), Лхагвасүрэнгийн гудамж, №12/2 дугаар барилга

10	0.0074	Трансформаторын барилга № 1	57.20	1	Улаанбаатар	Баянзүрх дүүрэг, 4-р хороо, 15-р хороолол (13344), Лхагвасүрэнгийн гудамж, ТП №12/1
11	0.7362	Хүүхдийн цэцэрлэг №19	1678.90	2	Улаанбаатар	Баянзүрх дүүрэг, 4-р хороо, 15-р хороолол (13344), Лхагвасүрэнгийн гудамж, №17 дугаар барилга
12	0.7775	Хүүхдийн цэцэрлэг №20	1678.90	2	Улаанбаатар	Баянзүрх дүүрэг, 5-р хороо, 15-р хороолол (13343), Рерихийн гудамж, №13 дугаар барилга
13	0.0140	Дэд станц /ЦТП/ №1	110.90	1	Улаанбаатар	Баянзүрх дүүрэг, 4-р хороо, 15-р хороолол (13344), Лхагвасүрэнгийн гудамж, ЦТП 6
14	0.0144	Дэд станц /ЦТП/ №2	110.90	1	Улаанбаатар	Баянзүрх дүүрэг, 5-р хороо, 15-р хороолол (13343), Энх тайвны өргөн чөлөө, ЦТП 7/1
15	0.0076	Трансформаторын барилга № 2	57.20	1	Улаанбаатар	Баянзүрх дүүрэг, 4-р хороо, 15-р хороолол (13343), Рерихийн гудамж, ТП 17/1



16	0.6058	Үйлчилгээний төв	7203.70		2	Улаанбаатар	Баянзүрх дүүрэг, 4-р хороо, 15-р хороолол (13343), Хилчдийн гудамж, №23/1 дүгээр барилга Баянзүрх дүүрэг, 4-р хороо, 15-р хороолол (13343), Хилчдийн гудамж, №23/2 дугаар барилга (гараж) Баянзүрх дүүрэг, 4-р хороо, 15-р хороолол (13343), Хилчдийн гудамж, №23/3 дугаар барилга Баянзүрх дүүрэг, 4-р хороо, 15-р хороолол (13343), Хилчдийн гудамж, №23/4 дүгээр барилга Баянзүрх дүүрэг, 4-р хороо, 15-р хороолол (13343), Хилчдийн гудамж, №23/5 дугаар барилга
	0.2364	Клуб/Соёлын төв	798.00		2	Дархан-Уул аймаг	Дархан сум, 5-р багийн засаг захиргааны нэгж
	0.3011	Орон сууц № 3	3113.90/ 2821.25		5	Дархан-Уул аймаг	Дархан сум, 4-р багийн засаг захиргааны нэгж

19	0.2759	Орон сууц № 4	3113.90/ 2821.25	5	Дархан-Уул аймаг	Дархан сум, 4-р багийн засаг захиргааны нэгж
20	0.6969	Орон сууц № 6	4564.00	5	Дархан-Уул аймаг	Дархан сум, 4-р багийн засаг захиргааны нэгж
21	0.0817	Орон сууц № 7	3113.90	5	Дархан-Уул аймаг	Дархан сум, 4-р багийн засаг захиргааны нэгж
22	0.4804	Хүүхдийн цэцэрлэг	1678.90	2	Дархан-Уул аймаг	Дархан сум, 4-р багийн засаг захиргааны нэгж
		Амбаар (хүүхдийн цэцэрлэгийн)	60.84	1		
23	0.3554	Дэлгүүр	1495.14	2	Дархан-Уул аймаг	Дархан сум, 4-р багийн засаг захиргааны нэгж
		Хашаа	938 м урт	-		
24	0.0056	Трансформаторын барилга	41.67	1	Дархан-Уул аймаг	Дархан сум, 4-р багийн засаг захиргааны нэгж
25	1.8886	Сургууль	4094.80	2	Дархан-Уул аймаг	Дархан сум, 5-р багийн засаг захиргааны нэгж
		Амбаар (сургуулийн)	52.90	1		
		Биеийн тамирын талбай	-			
26	0.0056	Трансформаторын барилга	41.67	1	Дархан-Уул аймаг	Дархан сум, 5-р багийн засаг захиргааны нэгж
27	0.1959	Офисын барилга /Хуучин дотуур байр/	1250.31	2	Дархан-Уул аймаг	Дархан сум, 5-р багийн засаг захиргааны нэгж
28	0.0243	Шүршүүрийн байгууламж	375.60	1	Дархан-Уул аймаг	Дархан сум, 5-р багийн засаг захиргааны нэгж



2) Хэлэлцээрт:

1 дүгээр зүйлийн тав дахь догол мөрийг дараах агуулга бүхий бичвэрээр солих:

“Оросын тал ОХУ-ын өмч болох орон сууцны барилга, соёл ахуйн объектууд болон өөрийн эрх ашиг, үүний дотор улсын хэрэгцээ, дипломат эрх ашгийг хангах үүднээс Зөвлөлтийн талд олгосон Улаанбаатар, Дархан хот (Дархан-Уул аймаг) дахь холбогдох эдэлбэр газрын хувьд хэлэлцэн тохиролцогч Талуудын хууль тогтоомж болон олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн өмчлөх эрх болон ашиглах эрхээ тус тус хэрэгжүүлнэ.

Монголын тал Улаанбаатар болон Дархан хот (Дархан-Уул аймаг) дахь эдэлбэр газар, тэдгээрт байрлаж буй ОХУ-ын өмчийн үл хөдлөх хөрөнгийн объектой холбоотой эрхийг Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын нэр дээрх бүртгэлээс Оросын Холбооны Улсын нэр дээр шинэчлэн бүртгэнэ. Монголын тал эдгээр газрыг оросын талд холбогдох ашиглалтын гэрээнд заасан нөхцөлийн дагуу 60 жилээр ашиглуулах, ингэхдээ цаашид ашиглалтын хугацааг 40 жилээр аливаа нөхцөлгүйгээр сунгах эрхтэйгээр шилжүүлж өгнө.

Холбогдох эдэлбэр газрыг цаашид ашиглах нөхцөлийг Талууд 100 жилийн хугацаа дуусахаас хоёр жилийн өмнө хэлэлцээ хийх замаар хэлэлцэн тохиролцоно.

Хавсралт 4-ийн дагуу Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын нэр дээрх бүртгэлээс Оросын Холбооны Улсын нэр дээр шинэчлэн бүртгэвэл зохих Монгол Улсын нутаг дэвсгэрт орших эдэлбэр газар болон тэдгээрт байрлах оросын үл хөдлөх хөрөнгийн объектуудын жагсаалт нь энэхүү хэлэлцээрийн салшгүй хэсэг болно.

Дээр дурдсан эдэлбэр газарт тэдгээрийн ашиглалтын зориулалтыг харгалзан Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн дагуу монголын хуулийн этгээдэд ногдуулдаг болон олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу ногдуулдаг татвар, хураамжийг ногдуулна.”;

Дараах агуулга бүхий Хавсралт 4 нэмэх:

ЗСБНХУ-аас БНМАУ-д нийлүүлж буй машин, тоног төхөөрөмж болон бусад эд ангийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэхэд зориулан зөвлөлтийн техникийн төвүүдийг байгуулахад зориулж БНМАУ-ын нутаг дэвсгэрт газар олгох, барилга барих нөхцөлийн тухай ЗСБНХУ-ын Засгийн газар, БНМАУ-ын Засгийн газар хоорондын 1979 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн хэлэлцээрийн Хавсралт 4.

**ЗСБНХУ-ын нэрнээс ОХУ-ын нэр дээр шинэчлэн бүртгэвэл зохих, Монгол Улсын нутаг дэвсгэрт орших газрын талбай болон тэдгээрт байрлах, хэлэлцээрийн дагуу барьж байгуулсан Оросын үл хөдлөх хөрөнгийн объектуудын жагсаалт**

№	Хамрах газрын хэмжээ (га)	Объект	Нийт/ашигтай талбай кв.м	Давхар	Хаяг
1	0.061	№17-р орон сууцны байрны 1 орц	1615.50/ 1374.36	9	Улаанбаатар Баянгол дүүрэг, 4-р хороо, 2-р хороолол (16052) Нарны зам
2	0.0081	Гараж	64.26/ 64.26	1	





Энэхүү ноот бичигт заасан татвар, хураамж ногдуулахыг тус Хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш газар ашиглалтын холбогдох гэрээг байгуулсан огнооноос эхлэн хэрэгжүүлнэ.

Ноот бичиг солилцох хэлбэрээр байгуулсан энэхүү хэлэлцээрийг протоколын хавсралт 1, хэлэлцээрийн хавсралт 4-т заасан эдэлбэр газрын хувьд Талууд тухайн газар ашиглалтын зориулалтаас хамаарч газар тус бүрт татвар ногдуулах журмыг тохиролцож, Талуудын Бүрэн эрхт төлөөлөгчид хамтарсан актад тусган гарын үсэг зурснаар мөрдөнө.

БНМАУ-д тусламж үзүүлж буй зөвлөлтийн мэргэжилтнүүдийг байраар хангах, үйлчлэх зорилгоор БНМАУ-д орон сууц болон хэрэгцээт соёл, ахуйн объектуудыг барих тухай ЗСБНХУ-ын Засгийн газар, БНМАУ-ын Засгийн газар хоорондын 1971 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн протокол болон ЗСБНХУ-аас БНМАУ-д нийлүүлж буй машин, тоног төхөөрөмж болон бусад эд ангийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэхэд зориулан зөвлөлтийн техникийн төвүүдийг байгуулахад зориулж БНМАУ-ын нутаг дэвсгэрт газар олгох, барилга барих нөхцөлийн тухай ЗСБНХУ-ын Засгийн газар, БНМАУ-ын Засгийн газар хоорондын 1979 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн хэлэлцээрийн дагуу баригдсан Монгол Улсад үнэ төлбөргүйгээр шилжүүлэх оросын үл хөдлөх хөрөнгийн хавсаргасан жагсаалт нь энэхүү хэлэлцээрийн салшгүй хэсэг болно.

Дээрх өөрчлөлттэй Монгол Улсын Засгийн газар санал нийлсэн тохиолдолд Оросын Холбооны Улсын Гадаад хэргийн яам Оросын Холбооны Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс энэхүү ноот бичиг болон Монгол Улсын Гадаад харилцааны яамны хариу ноот бичгийг БНМАУ-д тусламж үзүүлж буй зөвлөлтийн мэргэжилтнүүдийг байраар хангах, үйлчлэх зорилгоор БНМАУ-д орон сууц болон хэрэгцээт соёл, ахуйн объектуудыг барих тухай ЗСБНХУ-ын Засгийн газар, БНМАУ-ын Засгийн газар хоорондын 1971 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн протокол болон ЗСБНХУ-аас БНМАУ-д нийлүүлж буй машин, тоног төхөөрөмж болон бусад эд ангийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэхэд зориулан зөвлөлтийн техникийн төвүүдийг байгуулахад зориулж БНМАУ-ын нутаг дэвсгэрт газар олгох, барилга барих нөхцөлийн тухай ЗСБНХУ-ын Засгийн газар, БНМАУ-ын Засгийн газар хоорондын 1979 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Оросын Холбооны Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газрын хоорондын хэлэлцээр гэж үзэхийг санал болгох завшаан тохиов. Талууд энэхүү хэлэлцээрийг хүчин

төгөлдөр болгох талаар дотоодын хууль тогтоомжид заасан шаардлагатай арга хэмжээг авсан тухай сүүлчийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Энэхүү завшааныг ашиглан Оросын Холбооны Улсын Гадаад хэргийн яам Монгол Улсын Гадаад харилцааны яаманд гүн хүндэтгэлээ дахин илэрхийлж байна.»

Энэхүү ноот бичиг болон дээр дурдсан ноот бичгийг Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр гэж монголын тал үзэж байна.

Энэхүү завшааныг ашиглан Монгол Улсын Гадаад харилцааны яам Оросын Холбооны Улсын Гадаад хэргийн яаманд гүн хүндэтгэлээ дахин илэрхийлж байна.

Улаанбаатар хот,  
2019 оны 06 дугаар сарын 11-ний өдөр



Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газрын хооронд ноот бичиг солилцох замаар байгуулсан хэлэлцээрийн хавсралт.

**БНМАУ-д тусламж үзүүлж буй зөвлөлтийн мэргэжилтнүүдийг байраар хангах, үйлчлэх зорилгоор БНМАУ-д орон сууц болон хэрэгцээт соёл, ахуйн объектуудыг барих тухай ЗСБНХУ-ын Засгийн газар, БНМАУ-ын Засгийн газар хоорондын 1971 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн Протокол болон ЗСБНХУ-аас БНМАУ-д нийлүүлж буй машин, тоног төхөөрөмж болон бусад эд ангийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэхэд зориулан зөвлөлтийн техникийн төвүүдийг байгуулахад зориулж БНМАУ-ын нутаг дэвсгэрт газар олгох, барилга барих нөхцөлийн тухай ЗСБНХУ-ын Засгийн газар, БНМАУ-ын Засгийн газар хоорондын 1979 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн Хэлэлцээрийн дагуу барьж байгуулсан, үнэ төлбөргүйгээр Монгол Улсын өмчлөлд шилжүүлж буй Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлах оросын үл хөдлөх хөрөнгийн жагсаалт**

№	Хамрах газрын хэмжээ (га)	Үл хөдлөх хөрөнгө	Нийт/ашигтай талбай кв.м		Давхар	Хаяг
			3300.80/3025.00	3300.80/3025.00		
1	0.0775	Орон сууцны байр №1	3300.80/3025.00	3300.80/3025.00	5	Улаанбаатар Баянзүрх дүүрэг, 5-р хороо, 15-р хороолол (13343), Энх тайвны өргөн чөлөө
2	0.0842	Орон сууцны байр №7	3300.80/3025.00	3300.80/3025.00	5	Улаанбаатар Баянзүрх дүүрэг, 4-р хороо, 15-р хороолол (13343), Лхагвасүрэнгийн гудамж
3	0.1305	Орон сууцны байр №11	5381.50/4966.30	5381.50/4966.30	5	Улаанбаатар Баянзүрх дүүрэг, 4-р хороо, 15-р хороолол (13343), Лхагвасүрэнгийн гудамж
4	0.1244	Орон сууцны байр №12	5381.50/4966.30	5381.50/4966.30	5	Улаанбаатар Баянзүрх дүүрэг, 4-р хороо, 15-р хороолол (13343), Лхагвасүрэнгийн гудамж
5	0.0760	Орон сууцны байр №13	3300.80/3025.00	3300.80/3025.00	5	Улаанбаатар Баянзүрх дүүрэг, 4-р хороо, 15-р хороолол (13343), Лхагвасүрэнгийн гудамж

6	0.0074	Трансформаторын барилга № 1	57.20	1	Улаанбаатар	Баянзүрх дүүрэг, 4-р хороо, 15-р хороолол (13343), Лхагвасүрэнгийн гудамж, ТП 12/1
7	0.0140	<b>Дэд станц /ЦТП/№1</b>	110.90	1	Улаанбаатар	Баянзүрх дүүрэг, 4-р хороо, 15-р хороолол (13343), Лхагвасүрэнгийн гудамж, ЦТП 6
8	0.0144	<b>Дэд станц /ЦТП/№2</b>	110.90	1	Улаанбаатар	Баянзүрх дүүрэг, 5-р хороо, 15-р хороолол (13343), Энх тайвны өргөн чөлөө, ЦТП 7/1
9	0.0076	Трансформаторын барилга №2	57.20	1	Улаанбаатар	Баянзүрх дүүрэг, 5-р хороо, 15-р хороолол (13343), Рерихийн гудамж, ТП 17/1
10	0.3011	<b>Орон сууцны байр</b> № 3	3113.90/ 2821.25	5	Дархан-Уул аймаг	Дархан сум, 4-р багийн засаг захиргааны нэгж
11	0.2759	<b>Орон сууцны байр</b> № 4	3113.90/ 2821.25	5	Дархан-Уул аймаг	Дархан сум, 4-р багийн засаг захиргааны нэгж
12	0.0056	Трансформаторын барилга	41.67	1	Дархан-Уул аймаг	Дархан сум, 4-р багийн засаг захиргааны нэгж
13	0.0056	Трансформаторын барилга / сургуулийн/	41.67	1	Дархан-Уул аймаг	Дархан сум, 4-р багийн засаг захиргааны нэгж
14	0.061	Орон сууцны байр №17-ны хэсэг (1 давхрайн 166.42 кв.м оруулаагүй)	1449.08/1374.36	9	Улаанбаатар	Баянгол дүүрэг, 4-р хороо, 2-р хороолол (16052), Нарны зам



## МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БҮГД НАЙРАМДАХ БЕЛАРУСЬ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ЭКСПОРТЫН ЗЭЭЛИЙН ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар, цаашид “Хэлэлцэн тохиролцогч талууд” гэх,

Хоёр орны найрсаг харилцаа, худалдаа болон эдийн засгийн харилцааг улам өргөжүүлэн хөгжүүлэхийг эрмэлзэн,

Дараах зүйлийг харилцан тохиролцов.

#### 1 дүгээр зүйл Нэр томьёо

Энэхүү хэлэлцээрийн зорилгын хүрээнд дор дурдсан нэр томьёо дараах утгыг илэрхийлнэ. Үүнд:

а. “Зээлдэгч” - Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Монгол Улсын Сангийн яам;

б. “Зээлдүүлэгч” - Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газрыг төлөөлж Бүгд Найрамдах Беларусь Улсын Хөгжлийн банк;

в. “Эцсийн зээлдэгч” - Бараа, ажил, үйлчилгээ худалдан авч буй Монгол Улсын байгууллага;

г. “Беларусийн экспортлогч” - Бараа, ажил, үйлчилгээ үйлдвэрлэж буй Беларусь Улсын байгууллага;

д. “Гэрээ” - Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай Эцсийн зээлдэгч болон Беларусийн экспортлогч хоорондын аливаа гэрээ;

е. “Тусгайлсан зээлийн хэлэлцээр” - Гэрээ тус бүрийг санхүүжүүлэх зорилгоор байгуулах тусгай зээлийн хэлэлцээр;

ё. “Зээл” - Тусгайлсан зээлийн хэлэлцээрийн дагуу зээлдүүлэгчид шилжүүлсэн нийт үнийн дүн;



## **2 дугаар зүйл**

### **Зээлийн хэмжээ болон зориулалт**

1.Зээлдүүлэгч нь Беларусь Улсад үйлдвэрлэсэн (гүйцэтгэсэн, үзүүлсэн) бараа (ажил, үйлчилгээ)-г Монгол Улсад нийлүүлэх тухай гэрээ, цаашид “Гэрээ” гэх, тус бүрийн 85.0 хувийг санхүүжүүлэх зорилгоор Бүгд Найрамдах Беларусь Улсын Хөгжлийн банк хувьцаат компанид нийт тавин сая (50 000 000.00) еврогоос хэтрэхгүй хэмжээний зээл, цаашид “Зээл” гэх, -ийг Зээлдэгчид зээлдүүлэх бүрэн эрхийг олгохоор тохиролцов.

2.Зээлдэгч болон Бүгд Найрамдах Беларусь Улсын Хөгжлийн банк нар гэрээ тус бүрийг санхүүжүүлэх зорилгоор тусад нь зээлийн хэлэлцээр, цаашид “Тусгайлсан зээлийн хэлэлцээр” гэх, байгуулахаар тохиролцов.

3.Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газраас баталж гаргасан Беларусийн экспортлогчдийн жагсаалтаас Эцсийн зээлдэгч Беларусийн экспортлогчийг сонгоно.

4.Аливаа Тусгайлсан зээлийн хэлэлцээр байгуулагдаагүй тохиолдолд, эсхүл түүнийг байгуулах хүртэл Бүгд Найрамдах Беларусь Улсын Хөгжлийн банк ямарваа нэг төлбөр хийх үүрэг хүлээхгүй.

5.Зээлдэгч аливаа тусгайлсан зээлийн хэлэлцээрийн нийт хөрөнгийг Гэрээний үнийн дүнгийн наян таван (85%) хувийг санхүүжүүлэхэд ашиглана.

6.Зээлийн хөрөнгө ашиглах салбарыг Зээлдэгч болон Зээлдүүлэгч хэлэлцсэний үндсэн дээр тодорхойлно.

## **3 дугаар зүйл**

### **Тусгайлсан зээлийн хэлэлцээрийг батлах**

1.Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улсын хууль тогтоомжид нийцүүлэн бүх Тусгайлсан зээлийн хэлэлцээрийг батална.

2.Гэрээний бүх үнэ болон дүн нь еврогоор илэрхийлэгдэнэ.

3.Тусгайлсан зээлийн хэлэлцээрт тусгасан нөхцөлийн дагуу Гэрээний үнийн дүнгийн арван таван хувь (15%)-ийн санхүүжилтийг урьдчилгаа төлбөр болгон Эцсийн зээлдэгч төлнө.

4.Зээлдэгч болон Зээлдүүлэгч хооронд бичгээр өөрөөр тохиролцоогүй бол Тусгайлсан зээлийн хэлэлцээрийн хамгийн доод хэмжээ нь нэг сая (1 000 000) евро байна.



5.Зээл үүссэн өдөр гэж Зээлдэгчээс ирүүлсэн холбогдох төлбөрийн хүсэлтийн дагуу Беларусийн экспортлогчид Зээлийн эх үүсвэрийг шилжүүлсэн өдрийг хэлнэ.

#### **4 дүгээр зүйл Ерөнхий нөхцөл**

Тусгайлсан зээлийн хэлэлцээрийн хүрээнд зээлийн ерөнхий нөхцөлийг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

- а. Зээлийн эргэн төлөлтийн хугацаа 7 жилээс хэтрэхгүй байна;
- б. Зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа 2 жилээс хэтрэхгүй байна;
- в. Зээлийн хүү нь аливаа Тусгайлсан зээлийн хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрийн байдлаар тогтоосон еврогоор олгох зээлийн арилжааны нөхцөлийн жишиг хүү (АНЖХ) (ЭЗХАХБ-ийн гишүүн орнууд тухай бүр тогтоосон)-тэй тэнцүү байна.
- г. Зээлийн хүүгийн хугацаа нь жилийн 360 өдрийн суурь дээр бодогдоно.
- д. Зээлдэгч нь хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж төлөхгүй.

#### **5 дугаар зүйл Зээлийн эргэн төлөлт**

1. Тусгайлсан зээлийн хэлэлцээр бүрийн зээлийн эргэн төлөлтийг зургаан сар тутамд тэнцүү хэмжээгээр төлнө.
2. Зээлдэгч нь Тусгайлсан зээлийн хэлэлцээрийн хүрээнд тохиролцсон төлбөр төлөх огноо, зээлийн хүү төлөх хугацааны дагуу тооцсон зээлийн хүүгийн төлбөрийг төлнө.

#### **6 дугаар зүйл Татвар, хураамжаас чөлөөлөгдөх**

1. Зээлдэгч нь Монгол Улсын нутаг дэвсгэрт энэхүү зээлээр санхүүжүүлж буй бараа, ажил болон үйлчилгээг гаалийн татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар болон онцгой албан татвар, эсхүл түүнтэй адилтгах ямарваа нэгэн татвар, хураамжаас чөлөөлнө.
2. Энэхүү Ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хийгдэж буй үндсэн төлбөр нь Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улсын эрх бүхий байгууллагаас ногдуулах аливаа татвар, хураамжийн дүнг хасахгүйгээр тооцсон болно.

## **7 дугаар зүйл** **Маргаан шийдвэрлэх**

Энэхүү Ерөнхий хэлэлцээрийг тайлбарлах болон хэрэглэхтэй холбогдон гарсан аливаа маргаан болон зөрчлийг Хэлэлцэн тохиролцогч талууд хэлэлцэх, зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

## **8 дугаар зүйл** **Бусад**

1. Энэхүү Ерөнхий хэлэлцээр нь Хэлэлцэн тохиролцогч талууд түүнийг хүчин төгөлдөр болгох дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангасан тухайгаа дипломат шугамаар харилцан мэдэгдсэн сүүлийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү Ерөнхий хэлэлцээр нь тус хэлэлцээрт, түүнчлэн гэрээ болон тусгайлсан зээлийн хэлэлцээрт заасан бүхий л үүрэг бүрэн дуусгавар болох, Хэлэлцэн тохиролцогч талууд энэ тухай бичгээр тохиролцох хүртэл хүчин төгөлдөр байна.

3. Энэхүү хэлэлцээрт бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хэлэлцээр байгуулах замаар нэмэлт, өөрчлөлт оруулах бөгөөд энэ нь тус хэлэлцээрийн салшгүй хэсэг болно. Ийм нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хэлэлцээр нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан журмын дагуу хүчин төгөлдөр болно.

4. Бүх бичиг баримтыг Англи хэлээр, эсхүл Монгол, Орос хэлээр үйлдэж, Англи хэлээрх баталгаат орчуулгыг хавсаргана. Энэ тохиолдолд Англи орчуулга давуу хүчинтэй байна.

Улаанбаатар хотноо 2019 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Монгол, Орос, Англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй.

Энэхүү Ерөнхий хэлэлцээрийг тайлбарлахад зөрүү гарсан тохиолдолд Англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

**МОНГОЛ УЛСЫН**  
**ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

**ЧИМЭДИЙН ХҮРЭЛБААТАР**  
**САНГИЙН САЙД**

**БҮГД НАЙРАМДАХ БЕЛАРУСЬ**  
**УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

**АЛЕКСАНДР ОГОРОДНИКОВ**  
**АЖ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЯАМНЫ**  
**ОРЛОГЧ САЙД**





## МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР  
БОЛОН ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ,  
ХӨГЖЛИЙН БАНК ХООРОНД БАЙГУУЛСАН  
САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭР

### ЭНЭХҮҮ ХЭЛЭЛЦЭЭРИЙГ 2019 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр

- (1) Нэг талаас, **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**, түүнийг төлөөлж Монгол Улсын Сангийн яам (цаашид “Засгийн газар” гэх); болон
- (2) Нөгөө талаас, олон талт хэлэлцээрийн хүрээнд байгуулагдсан олон улсын байгууллага болох **ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК** (цаашид “**ЕСБХБ**” эсхүл “**Банк**” гэх) нарын хооронд байгуулав.

Удиртгал:

- (A) ЕСБХБ нь 1990 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн Банкнийг үүсгэн байгуулах тухай хэлэлцээр (“цаашид “Банкийг үүсгэн байгуулах хэлэлцээр” гэх)-т заасныг үндэслэж олон улсын нийтийн эрх зүйн дагуу байгуулагдсан олон улсын байгууллага бөгөөд Монгол Улс Банкнийг үүсгэн байгуулах хэлэлцээрт нэгдэн орж, 2000 оны 08 дугаар сарын 10-ны өдөр ЕСБХБ-ны гишүүн улс болсон.
- (B) Засгийн газар нь ЕСБХБ-ны Захирлуудын Зөвлөлийн 2017 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар батлагдсан Монгол Улстай хамтран ажиллах Стратегийн баримт бичгийн дагуу дэд бүтэц, зам тээврийн салбарын төслүүдийг санхүүжүүлэхэд ЕСБХБ-тай үргэлжлүүлэн хамтран ажиллахаа баталгаажуулж, илэрхийлсэн.
- (C) Банк нь Засгийн газарт удиртгал (B)-д тусгасан салбарт төсөл арга хэмжээ (цаашид “**Төсөл**” гэх)-д нийт 300,000,000 ам.доллараас хэтрэхгүй хэмжээний Засгийн газрын зээл (тус бүрийг “**Зээл**” гэх)-ийг олгох замаар санхүүжилт олгож болно. Ийнхүү санхүүжүүлэх Төсөл тус бүрийг Банк Засгийн газартай харилцан тохиролцож тухай бүр тодорхойлох бөгөөд санхүүжилтийг тусгайлсан зээлийн хэлэлцээр (“**Зээлийн хэлэлцээр**” гэх)-ийн дагуу олгоно.
- (D) Банк нь Засгийн газартай (дор тодорхойлсон) Санхүүжилтийн хэлэлцээрийг Төсөл тус бүрт байгуулахтай холбогдуулан, Засгийн газар нь Төсөл тус бүрт энэхүү хэлэлцээрийн 2, 3 дугаар зүйлд заасан нөхцөлийн дагуу дэмжлэг үзүүлэхээр тохиролцсон болно.

Дараах зүйлсийг харилцан тохиролцов:

## **НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ, НЭР ТОМЬЁО, ТАЙЛБАР**

### **1.01 дэх хэсэг. Хүчин төгөлдөр болох**

Талууд энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурж байгуулсан даруйд Засгийн газар нь Хэлэлцээрийг соёрхон батлах, Монгол Улсад хүчин төгөлдөр болоход шаардлагатай бүхий л дотоодын үйл ажиллагаа, дүрэм, журмыг хангах ажлыг цаг алдалгүй эхлүүлж, бүрэн хэрэгжүүлнэ. Засгийн газар нь Хэлэлцээрийг соёрхон батлах, хүчин төгөлдөр болгоход шаардлагатай дотоодын бүхий л үйл ажиллагаа, дүрэм, журам хангагдсаныг ЕСБХБ-д бичгээр шуурхай мэдэгдэж, Хэлэлцээрийг соёрхон баталсан тухай баримт бичгийн хуулбарыг ЕСБХБ-д хүргүүлнэ. ЕСБХБ уг мэдэгдлийг хүлээн авснаар энэхүү Хэлэлцээр соёрхон батлагдсан өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ.

### **1.02 дахь хэсэг. НЭР ТОМЬЁО**

Энэхүү Хэлэлцээрийн аль ч хэсэгт хэрэглэгдсэн (Удиртгал мөн адил хамаарна), хэрэв өөрөөр заагаагүй, эсхүл агуулга өөр утга агуулснаас бусад тохиолдолд, Удиртгалд заасан нэр томьёог харгалзуулан тодорхойлсон утгаар нь, Санхүүжилтийн хэлэлцээр бүрт заасан үг, хэллэгийг тухайн Санхүүжилтийн хэлэлцээрт заасан утгаар тус тус ойлгоно. Дор дурдсан нэр томьёо нь дараах утгыг илэрхийлнэ:

“Хэлэлцээр” гэж энэхүү Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг хэлнэ.

“Санхүүжилтийн хэлэлцээр” гэж аль нэг Санхүүжилтийн хэлэлцээрт “Санхүүжилтийн хэлэлцээр” гэж тодорхойлсон Зээлийн хэлэлцээр болон бусад хэлэлцээрийг хэлнэ.

“Тал” гэж энэхүү хэлэлцээрийн талыг хэлнэ.

“Худалдан авах ажиллагааны журам” гэж “Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны санхүүжүүлэх төслийн худалдан авах ажиллагааны



журам”-д заасан, нийтийн албаны үйл ажиллагаанд баримтлах ЕСБХБ-ны худалдан авах үйл ажиллагааны журмыг тухай бүр оруулсан нэмэлт өөрчлөлтийн хамт хэлнэ.

“Стандарт нөхцөл шаардлага”

гэж энэхүү хэлэлцээр байгуулсан өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй Банкны Стандарт нөхцөл шаардлагыг, тухай бүр оруулсан нэмэлт өөрчлөлтийн хамт хэлнэ.

### 1.03 ДАХЬ ХЭСЭГ. ТАЙЛБАР

Энэхүү Хэлэлцээр (Удиртгалын хамт)-д:

- (a) агуулга нь өөр утга агуулаагүй тохиолдолд, ганц тоогоор илэрхийлсэн үгс олон тоог, олон тоо нь ганц тоог илэрхийлнэ;
- (b) Эшилсэн зүйл, хэсэг, хавсралтыг энэхүү хэлэлцээрийн тухайлан эшилсэн зүйл, заалт, хавсралтаар ойлгоно;
- (c) (1) нэмэлт, өөрчлөлт эсхүл Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах хэмээн эш татсан нь нэмэлт, өөрчлөлт, эрхийн шилжүүлэг, үүргийг шинээр солих, дахин баталгаажуулах, дахин батлах зэргийг багтаасанд; болон  
(2) аливаа хэлэлцээрийг эш татсан нь тухайн хэлэлцээрт тухай бүр өөрчлөлт оруулсан хувилбарыг эш татсанд тооцогдоно;
- (d) гарчиг болон агуулгыг зөвхөн эшлэхэд хялбар байлгах зорилгоор оруулсан бөгөөд энэ нь хэлэлцээрийг тайлбарлахад нөлөөлөхгүй болно;
- (e) “хууль” гэж эш татсан аливаа хууль (нийтийн болон заншлын хэм хэмжээг хамааруулан) болон хэлэлцээр, үндсэн хууль, дүрэм, хууль тогтоомж, тогтоол, хэм хэмжээ тогтоосон акт, журам, шүүхийн шийдвэр, тушаал, хориг, тодорхойлолт, шийдвэр буюу бусад хууль тогтоох буюу захиргааны арга хэмжээ буюу аливаа улсын хуулийн хүчин чадал бүхий эсхүл тухайн хэм хэмжээг дагаж мөрдөх нь тухайн улсад ерөнхий практикт нийцэх шүүх буюу арбитрын шийдвэрийг ойлгоно;
- (f) аливаа хуулийн зүйл, заалтыг дурдсан нь тухай бүр нэмэлт, өөрчлөлт орсон эсхүл шинээр батлагдсан хуулийн зүйл, заалтыг дурдсан гэж ойлгоно;



- (g) аливаа этгээдэд хамаатуулсан “хяналт” (үүнд “хяналтад байгаа”, “нийтлэг хяналтад байгаа” мөн адил хамаарна) гэдгийг саналын эрхтэй хувьцаа эзэмшигч эсэхээс үл хамааран, хэлэлцээрээр, эсхүл бусад үндэслэлээр олгогдсон, удирдлагын чиглэл, бодлогыг шууд ба шууд бусаар тодорхойлох бүрэн эрхийг ойлгоно;
- (h) “этгээд” гэж дурдсан нь аливаа хувь хүн буюу хуулийн этгээд, фирм, компани, траст, засгийн газар, төр буюу төрийн агентлаг, аливаа холбоо, концерн, нөхөрлөл (хууль зүйн хувьд бие даасан эсэхээс үл хамааран), эсхүл дээр дурдсан хоёр буюу түүнээс дээш этгээдүүдийг ойлгох ба “этгээд” гэдэгт тэдгээрийн эрх залгамжлагч, зөвшөөрөгдсөн хүлээн авагч болон шилжүүлэн авагчийг багтаан ойлгоно; мөн
- (i) “хамааруулан, оролцуулан” гэж заасны ард “үүгээр хязгаарлагдахгүй” гэж заагаагүй байсан ч ийнхүү заасан байгаад тооцно.

## ХОЁРДУГААР ЗҮЙЛ. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮҮРЭГ

### 2.01 ДЭХ ХЭСЭГ. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

Банк өөрөөр зөвшөөрөөгүй бол, Засгийн газар Төсөл тус бүрийн хүрээнд хийгдэх Зээлийн хөрөнгө, эсхүл бусад хөрөнгөөр хамтран санхүүжүүлэх бүхий л бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг Худалдан Авах Ажиллагааны Журам (үүнд дор дурдсан заалтууд болон тэдгээрээр хязгаарлагдахгүй бусад хамаарна)-ын дагуу гүйцэтгэхийг баримтлахаа зөвшөөрч, амлаж байна. Тухайлбал:

- (a) Төсөл тус бүрт шаардлагатай, худалдан авалт нь зээлийн хөрөнгө, эсхүл бусад хөрөнгөөр хамтран санхүүжигдэх бараа, ажил, үйлчилгээ (2.01(b)-д заасан зөвлөх үйлчилгээнээс бусад)-г Худалдан авах ажиллагааны журмын 3 дахь хэсгийн 1, 2, 3 дугаар зүйлийн дагуу худалдан авна.
- (b) Төсөл тус бүрт Засгийн газрын авч ажиллуулах зөвлөх нарыг Худалдан авах ажиллагааны журмын 3 дахь хэсгийн 1, 2, 5 дугаар зүйлийн дагуу сонгон шалгаруулна.
- (c) Бүх хэлэлцээрийг Худалдан авах ажиллагааны журмын дагуу хянах бөгөөд Банк нь хэлэлцээр бүрийг урьдчилан хянана.



## 2.02 ДАХЬ ХЭСЭГ. САНХҮҮЖИЛТ

- (a) Төслүүдийг санхүүжүүлэхэд ЕСБХБ нь Засгийн газарт зээл олгож болно. Төсөл бүрт олгох зээлийг ЕСБХБ, Засгийн газартай тухай бүр хэлэлцэж тохирох бөгөөд Тусгайлсан зээлийн хэлэлцээрээр зохицуулна.
- (b) Зээлийн нөхцөлийг тухай бүр хэлэлцэж тохиролцоно. Зээл олгохоос өмнө ЕСБХБ-ны удирдлага, Захирлуудын Зөвлөлөөр батлуулах бөгөөд зээл нь дараах нөхцөлийг агуулж болно:
- Тогтмол, эсхүл хөрвөгч хүүн дээр нэмэх маржин нь Стандарт Нөхцөл, шаардлагад заасны дагуу жилийн нэг хувь (1%) байна.
  - Гадаад валютаар зээлийн хэмжээг илэрхийлнэ.
  - Зээлийн эргэн төлөгдөх хугацааг 10-18 жилээр тогтооно.
  - Төслийн онцлогоос хамаарч үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа 3-5 жил байна.
- (c) Төслүүдийг санхүүжүүлэхэд ЕСБХБ нь Засгийн газарт буцалтгүй тусламж олгож болно. Төсөл тус бүрт олгох буцалтгүй тусламжийг ЕСБХБ, Засгийн газартай тухай бүр хэлэлцэж тохирох ба үүнийг буцалтгүй тусламжийн хэлэлцээрээр зохицуулна.

## 2.03 ДАХЬ ХЭСЭГ. СТАНДАРТ НӨХЦӨЛ ШААРДЛАГА

Төсөл санхүүжүүлэхээр Засгийн газарт олгосон, эсхүл Засгийн газраас баталгаа гаргасан зээл, баталгаа, эсхүл санхүүгийн бусад хэрэгсэлтэй холбоотой, Банктай байгуулах хэлэлцээрүүдэд тухайн хэлэлцээрийн талууд Стандарт нөхцөл, шаардлагыг хүлээн зөвшөөрсөн тухай заалтыг тухай бүр тусгахаа Засгийн газар зөвшөөрч байна. Ийнхүү хэлэлцээрт тусгагдсанаар, хэлэлцээр байгуулах үед хүчин төгөлдөр үйлчилж байсан Стандарт нөхцөл, шаардлага нь хэлэлцээрийн нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилнэ.

## 2.04 ДЭХ ХЭСЭГ. НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАР БОЛОН ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨГДӨХ

Засгийн газар нь Төсөл тус бүрийн хүрээнд хийгдэх худалдан авалт буюу Зээлийн хөрөнгө, эсхүл бусад хөрөнгөөр хамтран санхүүжүүлсэн, эсхүл ЕСБХБ, бусад буцалтгүй тусламж олгогч байгууллагаас Засгийн газарт нэмж хөрөнгө оруулалтын зорилгоор олгосон буцалтгүй тусламжийн хөрөнгө (Засгийн газар, ЕСБХБ-ны хооронд байгуулсан буцалтгүй тусламжийн хэлэлцээрийн дагуу ЕСБХБ нь хөрөнгө оруулалтын зориулалтаар олгосон

буцалтгүй тусламжийг удирдан зохицуулна)-өөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг татвар (нэмэгдсэн өртгийн албан татварыг оруулах бөгөөд үүгээр хязгаарлахгүй) болон хураамж (гаалийн албан татварыг оруулах бөгөөд үүгээр хязгаарлахгүй)-аас чөлөөлөх буюу нөхөн олгоно.

## **ГУРАВДУГААР ЗҮЙЛ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

### **3.01. ДЭХ ХЭСЭГ. ХАМТЫН АЖИЛЛАГАА**

Засгийн газар нь энэхүү Хэлэлцээр болон холбогдох Санхүүжилтийн хэлэлцээрийн бүхий л нөхцөлийг дагаж мөрдөх үүднээс ЕСБХБ болон Төслийн зөвлөхүүдтэй хамтран ажиллана.

### **3.02 ДАХЬ ХЭСЭГ. ҮҮРЭГ ХҮЛЭЭХГҮЙ**

Энэхүү Хэлэлцээрээр ЕСБХБ нь аль нэг Төслийг санхүүжүүлэх үүрэг хүлээхгүй гэдгийг Талууд харилцан тохиролцсон болно. ЕСБХБ аль нэг Төслийг санхүүжүүлэх үүргийг Төсөл тус бүрээр хэлэлцэж байгуулах тусдаа Санхүүжилтийн хэлэлцээрээр хүлээх болохыг Талууд харилцан тохиролцсон болно.

## **ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. БУСАД НӨХЦӨЛ**

### **4.01 ДЭХ ХЭСЭГ. МЭДЭГДЭЛ**

Энэхүү Хэлэлцээрийн дагуу ЕСБХБ, эсхүл Засгийн газарт өгөх аливаа мэдэгдэл, хүсэлт болон бусад захидал харилцааг бичгээр үйлдэнэ. Энэхүү Хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол мэдэгдлийг Тал буюу Талуудын шаардсан, эсхүл зөвшөөрсөн дор дурдсан хаягаар, эсхүл аль нэг Талын нөгөө Талдаа мэдэгдсэн аливаа мэдэгдэл, хүсэлт, бусад захидал харилцааг хүлээж авах өөр хаягт биечлэн гардуулсан, шуудан, телекс, эсхүл факсаар дамжуулснаар мэдэгдэл өгсөн гэж үзнэ:

#### **Засгийн Газарт:**

Монгол Улсын Сангийн яам  
Засгийн Газрын II байр  
С.Данзангийн гудамж 5/1  
Улаанбаатар 15160, Монгол Улс.  
Хөгжлийн санхүүжилтийн газарт  
Факс: 976-51-267468

**ЕСБХБ-д:**

Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк

Уан Эксчэйнж Скуэйр

Лондон ИСи2Эй 2ЖэйЭн

Нэгдсэн Вант Улс

Үйл ажиллагааны удирдлагын газар, Үйл ажиллагааны дугаар:  
46955

Факс: +44-20-7338-6100

**4.02 ДАХЬ ХЭСЭГ. ХЭЛЭЛЦЭЭРИЙГ ДУУСГАВАР БОЛГОХ; НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ**

- (a) Аль ч тал хуанлийн жил дуусахаас 6 (зургаа)-аас доошгүй сарын өмнө Хэлэлцээрийг дуусгавар болгох тухай мэдэгдэл хүргүүлснээр энэхүү Хэлэлцээрийг цуцалж болно.
- (b) Хэрэв энэхүү Хэлэлцээр нь түүнд гарын үсэг зурснаас хойш 360 хоногийн дотор хүчин төгөлдөр болоогүй бөгөөд Банк ийнхүү хойшилсон шалтгааныг авч үзээд, энэхүү (b) заалтад заасан хугацааг сунгаагүй тохиолдолд энэхүү Хэлэлцээрт заасан Талуудын бүх үүрэг дуусгавар болно.
- (c) Хэлэлцээр дуусгавар болсон тохиолдолд дээрх (a) заалтыг үл хамааран, Хэлэлцээрийн 2, 3 дугаар зүйл цуцлагдахгүй бөгөөд Хэлэлцээрийг цуцлах үед хэрэгжиж байсан Төслүүдийн хувьд хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.
- (d) Энэхүү Хэлэлцээрийн аливаа нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, Тал тус бүрийн бүрэн эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурсан байна.

**4.03 ДАХЬ ХЭСЭГ. ЕСБХБ-НЫ ЭРХ, ХАЛДАШГҮЙ БАЙДАЛ**

Энэхүү Хэлэлцээрийн аль ч заалтыг ЕСБХБ нь “Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк байгуулах тухай Хэлэлцээр”, олон улсын гэрээ хэлэлцээр, эсхүл холбогдох хууль тогтоомжоор түүнд олгогдсон халдашгүй байдал, дархан эрх, эсхүл хөнгөлөлт чөлөөлөлтөөс татгалзсан, эсхүл өөрчилсөн гэж ойлгож тайлбарлахгүй.

#### **4.04 ДЭХ ХЭСЭГ. ХУВЬ; АНГЛИ ХЭЛ**

Энэхүү Хэлэлцээрийг Англи хэлээр гурван (3) эх хувь үйлдэнэ.

ДЭЭР ДУРДСАНЫГ ГЭРЧЛЭН, Талууд нь өөрийн бүрэн эрх бүхий албан тушаалтнаар төлөөлүүлэн энэхүү Хэлэлцээрийн эхэнд заасан өдөр өөрийн нэрийн харгалзах хэсэгт гарын үсэг зурсан болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

---

Нэр: Ч.Хүрэлбаатар

Албан тушаал: Монгол Улсын Сангийн сайд

ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ,  
ХӨГЖЛИЙН БАНК

---

Нэр: Ирана Кравченко

Албан тушаал: ЕСБХБ-ны Монгол Улс дахь суурин төлөөлөгч

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 2.5

**Индекс: 200003**